



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/95/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15



### 1.Хараат бус аудиторын дүгнэлт



#### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.09.25 № 177

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.БАТТУЛГА  
ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газар нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 84,0 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021289



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>158960774.00</b>	<b>159599770.50</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	270000.00	0.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	270000.00	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	270000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	150673301.00	152985807.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	0.00	2630000.00
35130	Эм боох материал	0.00	2630000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	35860401.00	35542907.00
35420	Аж ахуйн материал	35687907.00	33954232.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35450	Барилгын засварын материал	0.00	990000.00
35470	Бусад хангамжийн материал	172494.00	598675.00
35600	Мал амьтад	114812900.00	114812900.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	8017473.00	6613963.50
36300	Тэжээлийн нөөц	8017473.00	6613963.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>633276994.95</b>	<b>874548848.67</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	0.00	0.00
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	633276994.95	874548848.67
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	626264175.59	868075145.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	243302812.63	471163653.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5476775.16	-15139082.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78294800.00	112794800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46670833.48	-54963300.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	185625073.00	176399593.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-107933358.29	-105756602.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93339256.96	96916801.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37617582.99	-44693778.77
39209	Зам, гүүрийн байгууламж	71837618.00	71837618.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-20895491.52	-27860655.36
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5600000.00	5600000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	270525398.00	303203898.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-106026939.56	-122787997.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1000000.00	0.00
39217	Ном	1360198.00	1360198.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7012819.36	6473702.68
39301	Програм хангамж	11040250.00	11040250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7527430.64	-8066547.32
39303	Бусад биет бус хөрөнгө	3500000.00	3500000.00
<b>394</b>	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	0.00	0.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II</b>	<b>792237768.95</b>	<b>1034148619.17</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>792237768.95</b>	<b>1034148619.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	792237768.95	1034148619.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	632079492.89	632079492.89
51101	Өмч: - төрийн	632079492.89	632079492.89
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	66814636.15	308725486.37
51210	Өмнөх үеийн үр дүн	66814636.15	66814636.15
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	241910850.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	93343639.91	93343639.91



6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	792237768.95	1034148619.17
---	---	--------------	---------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>613982230.00</b>	<b>803626404.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10800722.00</b>	<b>237705284.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10800722.00	237705284.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10800722.00	237705284.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460722.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10340000.00	237705284.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>603181508.00</b>	<b>565921120.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	157549696.00	0.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	157549696.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	63172612.00	96759020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61303734.00	95720020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1868878.00	1039000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	382459200.00	469162100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	382459200.00	469162100.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	0.00	0.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	0.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>478643601.82</b>	<b>559970554.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>478643601.82</b>	<b>559970554.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	451596894.07	486840285.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212344613.57	277050170.46
210101	Үндсэн цалин	171279854.57	219673615.36
210105	Гэрээт ажлын хөлс	41064759.00	57376555.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27456261.18	35776430.55
210201	Тэтгэврийн даатгал	21805247.04	24861919.10
210202	Тэтгэмжийн даатгал	2246844.54	3364775.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	852374.51	2247641.62
210204	Ажилгүйдлийн даатгал	291172.99	1811729.33
210205	Эрүүл мэндийн даатгал	2260622.10	3490364.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6564837.00	8394879.96
210301	Гэрэл, цахилгаан	1199104.00	1980767.96
210302	Түлш, халаалт	5365733.00	6414112.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	58253015.62	36071880.90
210401	Бичиг хэрэг	4798530.70	3371350.00
210402	Тээвэр, шатахуун	36193754.60	19390775.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8741400.00	5580300.00
210404	Ном, хэвлэл	6500.00	1148000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1689937.50	752580.00
210408	Бараа материал акталсны зардал	6822892.82	5828875.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	464100.00	1000000.00
210502	Хоол, хүнс	376100.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	88000.00	1000000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9241200.00	1600000.00
210604	Урсгал засвар	9241200.00	1600000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5278000.00	3727800.00
210702	Дотоод албан томилолт	5278000.00	3727800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1385378.00	1407082.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	330390.00	359100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399200.00	259407.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	142000.00



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	22788.00	46575.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	130609488.70	121812041.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74093702.90	58202298.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56515785.80	63609742.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27046707.75	73130268.83
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	18521100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	18521100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	27046707.75	54609168.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27046707.75	54609168.83
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>135338628.18</b>	<b>243655849.95</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	0.00	0.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	30000000.00	1744999.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	30000000.00	1744999.73
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-30000000.00	-1744999.73
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>105338628.18</b>	<b>241910850.22</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>446092534.00</b>	<b>565921120.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>460722.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	460722.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	460722.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460722.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>445631812.00</b>	<b>565921120.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	0.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	63172612.00	96759020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61303734.00	95720020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1868878.00	1039000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	382459200.00	469162100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	382459200.00	469162100.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	0.00	0.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	0.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>446092534.00</b>	<b>565921120.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>446092534.00</b>	<b>565921120.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>419045826.25</b>	<b>492790851.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212344613.57	277050170.46
210101	Үндсэн цалин	171279854.57	219673615.36
210105	Гэрээт ажлын хөлс	41064759.00	57376555.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27456261.18	35776430.55
210201	Тэтгэврийн даатгал	21805247.04	24861919.10
210202	Тэтгэмжийн даатгал	2246844.54	3364775.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	852374.51	2247641.62
210204	Ажилгүйдлийн даатгал	291172.99	1811729.33
210205	Эрүүл мэндийн даатгал	2260622.10	3490364.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7398668.50	8821060.96
210301	Гэрэл, цахилгаан	1199104.00	1980767.96
210302	Түлш, халаалт	6199564.50	6840293.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50611016.00	30608205.90
210401	Бичиг хэрэг	3878250.00	3499850.00
210402	Тээвэр, шатахуун	34064166.00	19390775.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8741400.00	5679300.00
210404	Ном, хэвлэл	368400.00	1148000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3558800.00	890280.00



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	1979600.00	1000000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1979600.00	1000000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35174000.00	7524690.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16859300.00	2879690.00
210602	Тавилга	7505000.00	2055000.00
210604	Урсгал засвар	10809700.00	2590000.00
2107	Томилолт, зочны зардал	5278000.00	3727800.00
210702	Дотоод албан томилолт	5278000.00	3727800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2317578.00	1407082.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	330390.00	359100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399200.00	259407.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	142000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	932200.00	0.00
210807	Газрын төлбөр	22788.00	46575.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76486089.00	126875411.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76486089.00	126875411.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27046707.75	73130268.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	18521100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	18521100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27046707.75	54609168.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27046707.75	54609168.83
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	0.00
14	Бусад эх үүсвэр	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	632,079,492.89	93,343,639.91	66,814,636.15	0.00	792,237,768.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	632,079,492.89	93,343,639.91	66,814,636.15	0.00	792,237,768.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	632,079,492.89	93,343,639.91	66,814,636.15	0.00	792,237,768.95
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	632,079,492.89	93,343,639.91	66,814,636.15	0.00	792,237,768.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	632,079,492.89	93,343,639.91	66,814,636.15	0.00	792,237,768.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	241,910,850.22	0.00	241,910,850.22
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>632,079,492.89</b>	<b>93,343,639.91</b>	<b>308,725,486.37</b>	<b>0.00</b>	<b>1,034,148,619.17</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	419045826.25	409025827.25	469162100.00	413641000.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	419045826.25	409025827.25	469162100.00	413641000.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	419045826.25	409025827.25	450641000.00	395119900.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212344613.57	202324613.57	306315300.00	277050170.46
210101	Үндсэн цалин	171279854.57	161259854.57	206692000.00	219673615.36
210102	Нэмэгдэл			25686600.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			0.00	0.00
210104	Урамшуулал			0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	41064759.00	41064759.00	73936700.00	57376555.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27456261.18	27456261.18	49700800.00	35776430.55
210201	Тэтгэврийн даатгал	21805247.04	21805247.04	32802300.00	24861919.10
210202	Тэтгэмжийн даатгал	2246844.54	2246844.54	3981500.00	3364775.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	852374.51	852374.51	2182200.00	2247641.62
210204	Ажилгүйдлийн даатгал	291172.99	291172.99	3701800.00	1811729.33
210205	Эрүүл мэндийн даатгал	2260622.10	2260622.10	7033000.00	3490364.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7398668.50	7398668.50	7873100.00	8821060.96
210301	Гэрэл, цахилгаан	1199104.00	1199104.00	1973100.00	1980767.96
210302	Түлш, халаалт	6199564.50	6199564.50	5900000.00	6840293.00
210303	Цэвэр, бохир ус			0.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50611016.00	50611016.00	28612200.00	28996115.90
210401	Бичиг хэрэг	3878250.00	3878250.00	3603800.00	3068850.00
210402	Тээвэр, шатахуун	34064166.00	34064166.00	16670500.00	18289685.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8741400.00	8741400.00	4703500.00	5599300.00
210404	Ном, хэвлэл	368400.00	368400.00	2734400.00	1148000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал			0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3558800.00	3558800.00	900000.00	890280.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1979600.00	1979601.00	1000000.00	1000000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			0.00	0.00
210502	Хоол, хүнс			0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1979600.00	1979601.00	1000000.00	1000000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35174000.00	35174000.00	8058200.00	7524690.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16859300.00	16859300.00	5000000.00	2879690.00
210602	Тавилга	7505000.00	7505000.00	2058200.00	2055000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			0.00	0.00
210604	Урсгал засвар	10809700.00	10809700.00	1000000.00	2590000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	5278000.00	5278000.00	8624900.00	3527800.00
210702	Дотоод албан томиллолт	5278000.00	5278000.00	8624900.00	3527800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2317578.00	2317578.00	2019500.00	1407082.00



Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	0.00	0.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00	600000.00	600000.00
210803	Даатгалын үйлчилгээ	330390.00	330390.00	359100.00	359100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399200.00	399200.00	500400.00	259407.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	33000.00	360000.00	142000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	932200.00	932200.00	150000.00	0.00
210807	Газрын төлбөр	22788.00	22788.00	50000.00	46575.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	0.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>76486089.00</b>	<b>76486089.00</b>	<b>38437000.00</b>	<b>31016550.13</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76486089.00	76486089.00	38437000.00	31016550.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>18521100.00</b>	<b>18521100.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>18521100.00</b>	<b>18521100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	0.0	18521100.00	18521100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>383059200.00</b>	<b>382919922.00</b>	<b>469162100.00</b>	<b>469162100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>382459200.00</b>	<b>382459200.00</b>	<b>432162100.00</b>	<b>432162100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	382459200.00	382459200.00	432162100.00	432162100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>600000.00</b>	<b>460722.00</b>	<b>37000000.00</b>	<b>37000000.00</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих			37000000.00	37000000.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	0.0	0.0	0.00	0.00
122002	Хандив тусламж /гадаад/	0.0	0.0	0.00	0.00
<b>14</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	96209020.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	96209020.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	96209020.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	1562090.00
210401	Бичиг хэрэг	-	431,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,051,090.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	-	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-



2105	Нормативт зардал	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	94646930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	94,646,930.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	84084919.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	84084919.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	724,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	82,711,719.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	649,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 24-ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чулуунхороот сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чанартай хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чулуунхороот сумын ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.



Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 508,651.5 мянган төгрөгөөс тооцон 10,173.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11,234.3 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 241,910.8 мянган төгрөгөөр буюу 30,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө дансны өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	270.0		-270.0
Урьдчилгаа	0		
Бараа материал	158,690.8	159,599.8	909.0
Үндсэн хөрөнгө	965,425.4.0	1,253,816.8	288,391.4
Элэгдэл	-332,148.4	-379,268.0	-47,119.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>792,237.8</b>	<b>1,034,148.6</b>	<b>241,910.8</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	792,237.8	1,034,148.6	241,910.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>792,237.8</b>	<b>1,034,148.6</b>	<b>241,910.8</b>

Авлага данс үлдэгдэлгүй болж өөрчлөгдсөн. Энэ нь сургалтын төлбөрийн авлагыг барагдуулсантай холбоотой байна

Бараа материалын дансны үлдэгдэл 159,599.8 болж өссөн нь хангамжийн материал өссөнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,253,816.8 мянган төгрөг болж 288,391.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь АОНТХО-аар нэг цэгийн үйлчилгээний барилгын өргөтгөл, болон багийн барилгын ажлын хөрөнгө оруулалт, тээврийн хэрэгсэл авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,034,148.6 мянган төгрөг болж 241,910.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 189,644.2 мянган төгрөгөөр буюу 30,8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нэмснээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 81,327.0 мянган төгрөгөөр буюу 16,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт хэлмэгсдийн цалин хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь Засгийн газраас цалин хөлс нэмсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 461,162.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 461,162.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /код-70106/ хөтөлбөрийн 1 /код-80101/ арга хэмжээг санхүүжүүлэхээр 469,162.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс нийт 469,162.1 мянган төгрөгийг авч 100 хувь зарцуулсан байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 414,552.9 мянган төгрөг буюу 88,3 хувьтай байгаа нь ЗДНС-аас 6,302.2 мянган төгрөг, гэрээтээс 18,784,2 мянган төгрөг, багаас 15,584,6 мянган төгрөг, үндсэн данснаас 13,938.0 мянган төгрөгийг нийт 54,609.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин, томилолт зочны зардал, хангамж бараа материалын зардал тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь цар тахалтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны орлогыг дээд шатны төсвийн захирагчаас олгосон 89,711.9 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үй ажиллагаанаас 649,0 мянган төгрөг, ЗДНХ түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс 724,2 мянган төгрөг, тусламж хандиваар /корона/ 5,124.1 мянган төгрөг, нийт 96,209.2 мянган төгрөгийн орлогоор бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардал 96,209.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 142 мэдээллээс хугацаандаа оруулсан 126 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 14 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 153,761.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгөгдөж 100 хувийн биелэлттэй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,634.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,634.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал гараагүй тул залруулга хийгдээгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар хууль, журмын хэрэгжилттэй холбоотой дараах зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Чулуунхороот сумын ЗДТГ нь 469,162.1 мянган төгрөгийн 14 мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан нь Шилэн дансны 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор", 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.7 дах "байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгахад сумын Засаг даргын захирамжаар нийт 9,3 сая төгрөгийн хөрөнгийг урьдчилан төлөвлөх боломжтой, нэг



удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байгаа нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Чулуунхороот сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/95/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Чулуунхороот сумын ЗДТГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Чулуунхороот сумын ЗДТГ нь 469,162.1 мянган төгрөгийн 14 мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан	469,162.1	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Д.Баттулга Г.Одонтунгага
2	Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгахад сумын Засаг даргын захирамжаар нийт 9,3 сая төгрөгийн хөрөнгийг урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байгаа нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй	4,634.6	Албан шаардлага	Дарга	Д.Баттулга



<i>байсан” гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно” гэсэн заалтад нийцэхгүй байна.</i>				
<b>ДҮН</b>	<b>473,796.7</b>			